

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

### Дотоодын өрсөлдөөнт тендер шалгаруулалт

<b>Огноо:</b>	2022 оны 05 дугаар сарын 17-ны өдөр
<b>Төслийн дугаар нэр:</b>	P170676: Дэлхийн банкны санхүүжилттэй Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төсөл
<b>Тендер шалгаруулалтын дугаар, нэр:</b>	GO-CS-6: Дулааны шугамын трасс тодорхойлох, гэмтэл саатал илрүүлэх багаж, программ хангамж (сургалтын хамт) нийлүүлэх
<b>Тендер ирүүлэх сүүлийн хугацаа:</b>	2022 оны 06 дугаар сарын 30-ний өдөр 14:00 цагт

1. Энэхүү тендерийн урилга нь 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдөр Дэлхийн банкны “НҮБ-ын Бизнесийн Хөгжил” гадаад цахим хуудас дээр нийтэлсэн Төслийн Худалдан авах ажиллагааны Ерөнхий мэдэгдлийн дагуу зарлагдаж байна.

2. Монгол Улсын Засгийн газар нь Олон улсын хөгжлийн ассоциацийн зээлийн санхүүжилтээр “Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх” төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд, энэхүү төслийн хүрээнд GO-CS-6 дугаартай “Дулааны шугамын трасс тодорхойлох, гэмтэл саатал илрүүлэх багаж, программ хангамж (сургалтын хамт) нийлүүлэх” худалдан авах ажиллагааг санхүүжүүлнэ.

3. Эрчим хүчний яам эрх бүхий тендерт оролцогчдоос “Дулааны шугамын трасс тодорхойлох, гэмтэл саатал илрүүлэх багаж, программ хангамж (сургалтын хамт) нийлүүлэх” хийх зорилгоор битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

4. Тендер шалгаруулалтыг Дэлхийн Банкны Зээлдэгч нарт зориулсан худалдан авах ажиллагааны журам, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД МӨРДӨХ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА: Бараа, Ажил, Зөвлөх ба Зөвлөхийн бус үйлчилгээ (2016 оны 7 дугаар сар, 2020 оны 11 дүгээр сард шинэчилсэн)- ын дагуу дотоодын нээлттэй зах зээлд чиглэн өрсөлдөөнт тендер шалгаруулалтын аргаар явуулах бөгөөд худалдан авах ажиллагааны журамд тодорхойлсон эрх бүхий бүх тендерт оролцогчдод нээлттэй байна. Мөн Дэлхийн Банкны ашиг сонирхлын зөрчлийн талаар баримтлах бодлогыг уг журмын 3.4. Сонирхлын зөрчил хэсэгт заасныг үзнэ үү.

5. Сонирхсон эрх бүхий тендерт оролцогч нь ажлын өдрийн Улаанбаатарын цагаар 09:00 – 17:00 цагийн хооронд энэхүү урилгын төгсгөлд заасан хаягт хүрэлцэн ирж Төсөл хэрэгжүүлэх нэгжээс нэмэлт мэдээлэл авах, тендерийн баримт бичигтэй танилцах боломжтой.

6. Дотоодын давуу эрх тооцохгүй.

7. Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Борлуулалтын орлогын хэмжээ сүүлийн 3 жил (2019, 2020, 2021 он)-ийн аль нэг жилд гүйцэтгэсэн борлуулалтын орлогын хэмжээ нь 273,000,000.0 (хоёр зуун далан гурван сая) төгрөгөөс багагүй байх.
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: 195,000,000.0 (нэг зуун ерэн таван сая) төгрөгөөс багагүй байх.
- Санхүүгийн тайлан: Тендерт оролцогч нь сүүлийн 3 жил (2019, 2020, 2021 он)-ийн аудитлагдсан санхүүгийн тайланг ирүүлнэ.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгээс дэлгэрэнгүй шаардлагыг үзнэ үү.

8. Сонирхсон тендерт оролцогч нь урилгын төгсгөлд заасан хаягт хандан бичгээр хүсэлтээ гаргаж, 50,000 (тавин мянга) төгрөгийн хураамжийг эргэн үл төлөгдөх нөхцөлтэйгөөр төлсөнөөр тендерийн баримт бичгийг худалдан авч болно.

Төлбөрийн данс:

Дансны нэр: Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төсөл

Дансны дугаар: 100900011954

Банкны нэр: Төрийн сан банк.

Баримт бичгийг гадаад улсад илгээх тохиолдолд нэмэлт 150,000 (нэг зуун тавин мянга) төгрөгөөр буухиа шуудангаар хүргүүлэх болно. Эрчим хүчний яам нь баримт бичиг алга болох эсхүл хугацаа хоцорч хүргэгдсэнтэй холбоотой ямар нэг хариуцлага хүлээхгүй.

9. Тендерийг 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 14:00 цагт эсхүл түүнээс өмнө доорх хаягаар ирүүлнэ. Тендерийг цахимаар хүлээн авахгүй. Хугацаа хоцорсон тендерийг хүлээн авахаас татгалзана.

**Хаяг: Монгол Улс, 17060, Улаанбаатар хот, ХУД, III хороо, Чингисийн өргөн чөлөө Засгийн Газрын XIV байр, Эрчим хүчний яам, 3-р давхрын хурлын танхим**

Тендерийн хамт **7,800,000.0** (лолоон сая найман зуун мянган) төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ. Тендерийг 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 14:00 цагт доор заасан хаягаар хүрэлцэн ирж, нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдын төлөөллийг байлцуулан нээнэ.

*Хаяг: Монгол Улс, 17060, Улаанбаатар хот, ХУД, III хороо, Чингисийн өргөн чөлөө Засгийн Газрын XIV байр, Эрчим хүчний яам, 3-р давхрын хурлын танхим*

10. Энэхүү урилгын 7-р хэсэгт заасан Төсөл хэрэгжүүлэх нэгжийн хаяг:

*Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо,*

*Үйлдвэрчний гудамж, 67А байр, 1 давхар, 2 тоот*

*Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төсөл*

*Төсөл хэрэгжүүлэх нэгжийн Худалдан авалтын ажилтан Ч.Мөнхцацрал,*

*Утас:+976-77006589; И-мэйл: [ubhsjp6589mn@gmail.com](mailto:ubhsjp6589mn@gmail.com)*